

- Японд жирэмслэлт (хэвлийдээ хүүхэд тээх)-ийг шалтгаан болгож ажлаас халахыг хуулиар хориглодог.
 - Илгээгч байгууллага, Хянагч байгууллага нь таны жирэмслэлтийг шалтгаан болгож, **та өөрөө дадлагаа үргэлжлүүлэхийг хүсч байхад, таныг нутаг буцаах явдал байж болохгүй.**
 - Ажлаасаа халагдаж болзошгүй болох юм уу таныг нутаг буцахыг шаардвал, **Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (ОТІТ)-аас зөвлөгөө хүсээрэй.** ОТІТ танд туслах болно.
- ※Холбоо барих мэдээллийг арын хуудаснаас харна уу.

Жирэмсэлвэл яах вэ?

- ☑ Жирэмсэлвэл, Хянагч байгууллагын зөвлөгөө авах боломжтой газар, дадлага хийж байгаа газрынхаа хүнд жирэмсэлсэн гэдгээ мэдэгдээрэй.
- ☑ Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага болон таны оршин суугаа нутагт ч зөвлөгөө авах боломжтой газар байгаа. ※Холбоо барих мэдээллийг арын хуудаснаас харна уу.
- ☑ Оршин суугаа нутгийнхаа хариуцсан албанд жирэмслэлт мэдэгдэх мэдэгдэл хураалгаарай.
- ☑ Оршин суугаа нутгийнхаа хариуцсан албанаас эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (Хэвлийдээ хүүхэд тээж байгаа хүн оршин суугаа нутгийнхаа захиргааны газраас авдаг дэвтэр. Нярай болон эхийн эрүүл мэндийн талаар бичиж тэмдэглэхэд зориулсан дэвтэр.) болон жирэмсний хяналт (оршин суугаа нутгийн захиргааны газар нярай эрүүл бойжиж байгаа эсэхийг хянана.)-анд хамрагдах ваучер зэргийг авах боломжтой байдаг учраас, жирэмсний хугацаанд тогтмол жирэмсний хяналтанд хамрагдаарай.

Жирэмсэлсэн ч ажлаа хийх боломжтой юу?

- ☑ Японд жирэмслэлт зэргийг шалтгаан болгож ажлаас халах явдал, танд хохиролтой зүйл хийхийг хориглодог. Жирэмсэлсэн ч та өөрөө дадлагаа үргэлжлүүлэхийг хүсч байгаа бол ур чадварын дадлагаа үргэлжлүүлэх боломжтой.
- ☑ Японд хүүхэд төрөх товт өдрөөс 6 долоо хоногийн өмнөөс ажлаасаа чөлөө авах боломжтой байдаг.

Ажлаасаа чөлөө авч, чөлөө авсан хугацаанд цалин олгогдохгүй тохиолдолд, таны хамрагддаг эрүүл мэндийн даатгал (компанид ажил эрхэлдэг хүмүүсийн хамрагддаг даатгал. Даатгалд хамрагдагчдаас даатгалын шимтгэл хурааж, түүгээрээ гэмтэж бэртэх юм уу өвчин тусаад эмнэлэгт үзүүлж буй хүмүүст тусалдаг систем.)-аас төрөлтийн тэтгэмж (ердийн үеийн цалингийн 60% орчмын мөнгө) авах боломжтой.

Хүүхдээ төрүүлсний дараа ур чадварын дадлагаа үргэлжлүүлэх боломжтой юу?

- ☑ Японд хүүхдээ төрүүлсний дараа, таны эрүүл мэндийг бодолцож, 8 долоо хоног ажил хийх боломжгүй байдаг. Үүний дараа, дахин ур чадварын дадлагаа хийж эхлэх боломжтой.

Ажлаасаа чөлөө авч, чөлөө авсан хугацаанд цалин олгогдохгүй тохиолдолд таны хамрагддаг эрүүл мэндийн даатгалаас төрөлтийн тэтгэмж авах боломжтой.

- ☑ Ур чадварын дадлагаа түр зогсоож, нутагтаа харьж хүүхдээ төрүүлсэн тохиолдолд ч мөн дахин Японд ирж, ур чадварын дадлагаа хийж эхлэх боломжтой. (Хүсэлт гаргах шаардлагатай.)
- ☑ Ур чадварын дадлагаа түр зогсоосны дараа, дахин ур чадварын дадлагаа хийж эхлэхийн тулд, Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага зэрэг газарт хүсэлт гаргах шаардлагатай. Хэзээ эхлэхийг хүсч байгаагаа Хянагч байгууллага, Дадлагыг хэрэгжүүлэгч этгээддээ мэдэгдээрэй.

**Асуудал гарвал Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (ОТИТ)-аас зөвлөгөө аваарай.
(Утсаар, и-мэйлээр зөвлөгөө авах боломжтой.)**

Зөвлөгөө авах боломжтой хэл	Зөвлөгөө авах боломжтой өдөр, цаг	Утасны дугаар	OTIT URL
Вьетнам хэл	Даваа-Баасан, Бямба 11:00-19:00 (Бямба: 9:00-17:00)	0120-250-168	https://www.support.otit.go.jp/soudan/vi/
Хятад хэл	Даваа, Лхагва, Баасан 11:00-19:00	0120-250-169	https://www.support.otit.go.jp/soudan/cn/
Индонези хэл	Мягмар, Пүрэв, Бямба 11:00-19:00 (Бямба: 9:00-17:00)	0120-250-192	https://www.support.otit.go.jp/soudan/id/
Филиппин хэл	Мягмар, Пүрэв, Бямба 11:00-19:00 (Бямба: 9:00-17:00)	0120-250-197	https://www.support.otit.go.jp/soudan/phi/
Англи хэл	Мягмар, Пүрэв, Бямба 11:00-19:00 (Бямба: 9:00-17:00)	0120-250-147	https://www.support.otit.go.jp/soudan/en/
Тайланд хэл	Пүрэв, Ням 11:00-19:00 (Ням: 9:00-17:00)	0120-250-198	https://www.support.otit.go.jp/soudan/th/
Камбодж хэл	Пүрэв 11:00-19:00	0120-250-366	https://www.support.otit.go.jp/soudan/kh/
Мьянмар хэл	Мягмар 11:00-19:00	0120-250-302	https://www.support.otit.go.jp/soudan/mm/

Жирэмслэлттэй холбогдох санаа зовоосон зүйл юм уу ахуй амьдралтай холбоотой асуудал үүсвэл, оршин суугаа бүсийнхээ Зөвлөгөө өгөх газраас мөн зөвлөгөө авах боломжтой.

Гадаадын иргэдийн ахуй амьдралыг дэмжих портал сайт	https://www.moj.go.jp/isa/content/930004512.pdf ※Бүс нутгаасаа хамааран зөвлөгөө авах боломжтой хэл харилцан адилгүй байна.
Олон орны гадаад хэл дээр ахуй амьдралын зөвлөгөө өгөх цонх (Орон нутгийн захиргааны байгууллагуудын олон улсын харилцааны Зөвлөл)	https://www.clair.or.jp/j/multiculture/association/consultation_list.html

“Япон улсад ажиллаж амьдрах гарын авлага”-д мөн хүүхэд төрүүлэх, хүүхэд асрах талаар мэдээлэл бичигдсэн байгаа.
<https://www.moj.go.jp/isa/support/portal/index.html>

Бичигдсэн хэл: Япон (Хялбар Япон хэл орно), Англи, Хятад, Солонгос, Испани, Португал, Вьетнам, Непал, Тайланд, Индонези, Мьянмар, Кхмер (Камбодж), Филиппин, Монгол, Турк, Украин

